

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭНГЭГМЭЭГЭЭ УХЛААНЫ ФАКУЛЬТЕТ

ТҮҮЖ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ № 488 (14) 2002 он

RUSSIA



Гарчиг

Эрхэм уншигч Танаа

5

Монголын түүх

1. П.Дэлгэржаргал. Мэнгу шивэй аймгийн угсаа гарлыг нэхэн сурвалжлах нь. 8
2. Д.Хүүхэнбаатар, П.Дэлгэржаргал. Монголын үндэсний нэгдэх хөдөлгөөний түүхийн асуудал. (XX зууны эхний хагас). 12
3. Д.Энхцэцэг. Үндэсний эв нэгдэл- тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн баталгаа болох нь. 18
4. Ж.Урангуа. XX зууны эхэн үеийн Ар Монгол дахь гадаадынхны үйл ажиллагаа. 23
5. З.Лонжид. Дундат иргэн улсаас Монголын тухай баримталсан бодлогыг нэхэн судлахуй. (1919 оноос хойш) 29
6. С.Отгонжаргал. XX зуунд Монголд гарсан хөрөнгөлөг ардчилсан хувьсгалын асуудалд. 34
7. Н.Хишигт. Монголын түүхэнд Барон Унгерний холбогдох нь /1921-1925/ 42
8. Б.Пунсалдулам. Монгол дахь Буриадын хурал. 51

Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

1. Б.Ралгаа. Монгол оронд бурханы шашин дэлгэрсэн нь. 57
2. С.Түвшин. Ж.Цэвээний улс төр, нийгэм-эдийн засгийн үзэл баримтлалын тухайд. 68
3. З.Баасанжав. МУИС байгуулагдсан түүхээс. 73
4. Л.Ариунаа. Монголд өөрөө удирдах ёсны түүхэн уламжлал байсан уу? (Бодрол, тэмдэглэл). 78

Байгаль хамгаалах түүхэн уламжлал

1. Ж.Болдбаатар, С.Дэмбэрэл. Монголчуудын байгаль орчноо хамгаалах зан заншил, хууль тогтоомжийн түүхэн тойм (Нэн эртнээс XX зуун). 80
2. Л.Чулуунбаатар. Ган зудын гамшиг, гэтлэн давах арга замын тухайд. 99

Гадаад харилцааны түүх

1. Ута Шёне. 1920-иод онд Герман улсад суралцаж байсан монгол сурагчдад болон Лайпцигт хэвлүүлсэн монголын газрын зургийн түүхэнд холбогдох зарим тэмдэглэл. 104
2. Р.Төрдалай. Франц улсын Парис хотын монгол сурагчид /Түүхэн тэмдэглэл/. 110

Түүх бичлэг

1. Удо Баркманн. Монголын түүхийн талаархи олон улсын судалгаа: Эзгүйрэл, улс төрийн ашиг хонжоо хоёрт идэгдсэн Монголын түүх. 114
2. Б.Пунсалдулам. 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчдын тухай түүх бичлэгийн зарим асуудалд. 127

Түүхэн газар зүй

1. Д.Сүхбаатар. Монгол орны түүхэн газар усны нэрийн тухай. 133

Хавсралт

1. Түүхийн салбарыг төгссөн алдартнууд 137
2. Зохиогчдын товч танилцуулга 139

**Монголд өөрөө удирдах ёсны түүхэн
уламжлал байсан уу?
/Бодрол, эргэцүүлэл/**

Магистр Л.Ариунаа /МУИС/

Хүн төрөлхтөн өөрсдийгөө нийгмийн зохион байгуулалтад оруулахын тулд удирдлагын олон янзын хэлбэрийг бодож олжээ. Тэр бүхнээс хүн ард өөрсдийгөө нийгмийн зохион байгуулалтад оруулах талаар бодож олсон хамгийн аугаа их үнэт зүйл бол төр юм. Ингэж төрийн удирдлага нь нийгмийн удирдлагын үндсэн төрөл болсон боловч, өөрөө удирдах ёс өөрийнхөө харьцангуй бие даасан байдлыг хадгалан үлдсэн бөлгөө.

Нутгийн өөрөө удирдах ёс хэмээх ойлголт нь Францын хувьсгалын үед төртэй харилцах үйл хэрэгт нь оролцох хүмүүсийн нийтлэгийн бие даасан байдал гэсэн утгаар анх судалгааны эргэлтэнд оржээ.

Германы эрдэмтэн Штейн “Иргэд орон нутгийн түвшинд төрийн хэрэгт оролцох хэлбэр нь өөрөө удирдах удирдлага мөн” гэж тодорхойлжээ.

Нийгмийн шаардлага тодорхой ашиг сонирхлын үүднээс хамтын амьдралд оролцож, тэрхүү үйл явцаа залж чиглүүлэх нь хүмүүн ёсны салшгүй нэг гол шинж юм. Үүнээс төрийн удирдлага төдийгүй, өөрөө удирдах ёсны зарчим шууд урган гарах бөгөөд монголчууд ч нэн эртнээс энэ л жамыг дагаж амьдрал ахуйгаа хөтөлж байсан юм. МЭӨ 209 онд Монголын төр ёсны эхийг тавьсан Хүннүгээс илүү бодитой болж цаашид монголын эртний улсуудад илүү гүнзгийрэн, Монгол улсын үед төрийн дээд байгууллагын шинжийг олж эхэлсэн. Их хуралдай нь нийгмийн удирдлагын үндсэн хоёр төрөл болох төрийн удирдлага, өөрөө удирдах удирдлагын нэг ёсны хослол, эхлэл болж байсан бөлгөө.

Монголчууд тэнгэрийн дор төрж , төрийн дор амьдрана хэмээн өгүүлэхдээ өөрөө удирдах ёсыг ч бас төр ёс амьдрал, ахуйн эрхээр баримталсаар байсан юм.

Энэ нь монголчуудын нүүдлийн амьдрал, аж ахуйн онцлогоос үүдэн гарч байсан билээ. Учир нь нүүдлийн амьдрал, аж ахуй нь амиа аргацаан хувиа бодож , довоо шарлуулах, төдийгөөр хязгаарлагдаж байсангүй, хөдөлмөрөө хэмнэх хорших хамтран ажиллах дадлага туршлагаа харилцан солилцох, нийтэч эвсэг уур амьсгалыг эрхэмлэх, тодруулж хэлбэл, зохион байгуулалтын тун өвөрмөц хэлбэрийг шаардаж байсан юм. Үүнийг нүүдэлчдийн өөрөө удирдах ёсны бүрдэл хэмээн томъёолж болохоор байна. Энэ нь хот айл, айл саахалт, нэг голынхон зэрэг хэлбэрээр илэрч байв. Тухайлбал эртний монголын цэрэг-аж ахуйн нэгж болох хүрээ нүүдэл аажмаар задарснаас үүдэлтэй хот айл нь нүүдлийн сонгодог мал аж ахуй эрхлэх, малчдын хүч хөдөлмөрөө нэгтгэж аж төрөх, өөрөө өөрийгөө удирдан зохион байгуулах гол хэлбэр бөгөөд малчдын хоорондын цогц харилцаа ялангуяа малчин хүний амьдралын өдөр тутмын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх нутаг усны өөрөө удирдах ёсны өвөрмөц байдлыг илэрхийлж байв.

Нүүдэлчдийн өөрөө удирдах удирдлагын гол субъект нь амьдралын тогоонд, чанагдаж хатаагдсан хөдөөгийн хөх өвгөд байсан гэж хэлж болно.

Тэднийг хэн ч томилохгүй, айл саахалт, нутаг усандаа нэр хүндээрээ тодорч аяндаа тэдний амыг харах байдалтай болж байсан бөгөөд нэг ёсны албан ёсны бус хошуучлагчийн байр сууринд гарч ирж байсан юм. Ард олон тэдгээр нэр хүнд бүхий өвгөдтэй өргөдөл зарга үйлдэх, төрийн захиргааны орон нутгийн байгууллагатай хэл амаа ололцох, мал адуулах арга ухаан, цаг агаарын

Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

байдлыг тандах, өвөлжөө бууцаа сонгох, наймаа арилжаа хийх үр хүүхдийнхээ заяа төөргийг ярилцах зэрэг амьдрал ахуйнхаа тулгамдсан асуудлыг асууж зөвлөн, тэдний зөвлөгөөг гүн хүндэтгэлтэй бишрэн сонсож хэрэгжүүлдэг байжээ. Харин нутгийн өөрөө удирдах ёсны ийм бүрдлийг төрөөс эрх зүйн хувьд хуулиар бататгаж байгаагүй зөвхөн заншлын эрхийн хэм хэмжээгээр аяндаа зохицуулагдаж байсан гэж хэлж болно.

1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын үрээр монголчууд хүний эрх, эрх чөлөөний наад захын эрхийг эдэлж эхэлсэн юм. Бидний монголчууд төрийг удирдах хэрэгт ямар анги бүлэгт хамаарагдах эсэхээс шалтгаалан төрийг удирдах хэрэгт оролцох болов. Төрийн тогтоосон хэм хэмжээний хүрээнд эрх ашгийн нийтлэгийг тодорхой түвшинд төлжүүлэн хөндсөн бүхэн нутгийн эрх хэмжээний асуудал байдаг нь хэнд ч тодорхой.

Нутгийн өөрөө удирдах ёс нь:

- Бүх нийтийн, тэгш, шууд сонгуулийн эрхийн үндсэн дээр нууцаар санал хурааж явуулсан сонгуулийн дүнд сонгогдсон гишүүд, сонгогчдоо төлөөлж эдлэх эрх;

- Өөрт нь тайлагнадаг гүйцэтгэх байгууллагатай хамт, удирдлагыг хэрэгжүүлэх явдал гэж үзвэл, БНМАУ-ын IX их хурлаас сонгуулийн тогтолцоог шинэчилсэн үеэс нутгийн өөрөө удирдах ёсны бүрдэл тодорхой хэмжээгээр байсан хэмээн үзэж болно.

Тэгэхлээр 1950-иад оны хөдөлмөрчдийн депутатуудын хурал 1960-1990 онд үйлчилсэн орон нутгийн ардын депутатуудын хурлын бүх шатны байгууллагын үйл ажиллагаанд нутгийн өөрөө удирдах ёсны бүрдэл сонгодог утгаараа биш ч гэсэн ямар нэг хэмжээгээр байсан гэж хэлж болно.

1980-иад оны II хагасаас манай сонин, хэвлэлд өөрөө удирдах ёс, нутгийн өөрөө удирдах ёсны асуудлаар бичиж, санал бодлоо илэрхийлэх болсон нь 1992 оны шинэ Үндсэн хуульд уг асуудлыг жинхэнэ утгаар тавих урьдач нөхцлийг оюун санаа, сэтгэл зүйн хувьд бүрдүүлсэн бөлгөө.

Монгол улсын шинэ Үндсэн хуульд төрийн удирдлагыг орон нутгийн өөрөө удирдах ёстой хослуулах зарчмыг дэвшүүлэн хэрэгжүүлж байна. Харин орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага-аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, баг, хорооны Иргэдийн нийтийн хурлын үйл ажиллагааг улам боловсронгуй болгох, идэвхжүүлэх шаардлага тулгарч байна. Үүнд монголчуудын өөрөө удирдах ёсны уламжлалыг ашиглах нь чухал юм.